



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 04 сарын 13 өдөр

Дугаар 1/16

Чингис хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйл, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 06 дугаар тогтоолын 07 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2018 оны Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газрын албан хаагчдын дүрэмт хувцас худалдан авах, Баян-Овоо, Цэнхэрмандал, Дадал сумдад ногоон байгууламж нэмэгдүүлэх ажил, Ойжуулалтын ажил, Ус зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх төхөөрөмж Баянхутаг, Баян-Овоо сумдад суурилуулах ажил, Хэрлэн сумын Өндөрхаан хот тохижилт ОНТҮГ-т усны авто машин худалдан авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Б.Нямхатан	-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Ойн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Нарийн бичгийн дарга:	Ц.Бат-Эрдэнэ	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
Гишүүд:	О.Гомбобаатар	-Өндөрхаан хот тохижилт ОНТҮГ-ын хүний нөөцийн мэргэжилтэн
	Б.Гүрсүрэн	-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Ойн албаны мэргэжилтэн
	Н.Оюунмандал	-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Усны асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Ойн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нямхатан/-д даалгасугай.

ДАРГА Ж.ГАНБААТАР

